

"ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА, ДЭГ ЖУРАМ, ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ"
2025 ОЫН 01, 03, 04 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ
(ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ)

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ
1	2	3	4	5	6
1	1	ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА, ДЭГ ЖУРАМ, ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ, БҮТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ 2025-06-18 ДУГААР 2025_01	1.1.. Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах;	Тус институт нь захиргааны аливаа шийдвэр гаргахдаа батлагдсан ISO 9001:2013 MNS стандартын дагуу ерөнхий инженер, ерөнхий менежер, хэлтсийн дарга нар, хуульч, мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудаас санал авч ажиллаж байна. Тайлант хугацаанд тус институттай холбоотой аливаа гомдол санал иргэдээс ирээгүй болно.	100
	2		1.2.. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;	Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд гаргах зорилгоор мөрт зэрчмыг баримтлан олон жил ажилласан чадварлаг боловсон хүчнүүдийг дэмжин мэргэжилтэн болон инженерээс хэлтсийн дарга, ерөнхий инженер хүртэл дэвшүүлэн ажиллаж байна.	100
	3		1.3.. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх;	Тус институт нь төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх албан даалгаврын хэрэгжилтийг ханган байгууллагын нийт орон тоо, ажлын байрыг 10 хувиар багасган, 9 хэлтэс, 74 орон тоотойгоор шинэчлэн зохион байгуулж үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөн саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан тоотгоор хүргүүлэн ажиллаж байна.	100

4	1.6.. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тус институт нь дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд тухайлан тусгай зөвшөөрөл шаардагддаг инженер, геологи, байр зүй, байгаль орчны үнэлгээ гэх мэт ажлууд болон бусад ажлууд дээр хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллага зөвлөхүүдийг гэрээлэн авч, ажиллуулж байна. 2025 оны байдлаар хувийн хэвшлийн 16 байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.	100
5	1.8.. Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, зөвлөлийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах.	УИХ-ын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганд өргөн барьж, хэлэлцүүлэхээр дэмжүүлээд байна.	100
6	2.1.. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;	Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд аливаа хууль, тогтоомж зөрчсөн зөрчил гараагүй болно.	100
7	2.2.. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Төрийн болон албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу байгууллагын албан ёсны веб хуудас болон www.shieldands.gov.mn цахим хаягт сар болгоны 05-ны өдөрт багтаан оруулж нийтэд ил тод болгон ажиллаж байна.	100
8	2.4.. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдлтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх;	Монгол Улсын Их хурлын 2023 оны 59 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" /2024-2030 он-ийн дагуу байгууллагын "Авлигатай тэмцэх хөтөлбөр"-ийг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 3 зорилт, 11 арга хэмжээтэйгээр батгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Байгууллагын даргын дэргэд Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулан ажиллаж байна.	100

9	2.5.. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх;	Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх, аливаа хэлбэрийн дарамт, шахалтаас ангид байлгах чиглэлээр албан хаагчийн томилгоо, чөлөөлөлтийг зөвхөн хууль, дүрэм журмын хүрээнд зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагаанд аливаа улс төрийн болон хувийн ашиг сонирхлын нөлөөллийг үл зөвшөөрөх зарчмыг чанд баримтлан ажиглаж байна.	100
10	2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилогтыг хязгаарлаж, тансгалтыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиглах.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах 20 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиглагаандаа мөрдөн ажиглаж байна. Мөн байгууллагын орлого нэмэгдүүлж, алдагдал бууруулах ажлын төлөвлөгөөг 9 чиглэл, 20 хэрэгжүүлэх үйл ажиглагаатайгаар боловсруулж, газрын даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиглаж байна. Шилэн дансны хуулийн дагуу байгууллагын 2024 оны 12 дугаар сар, 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тооцоо, орлогын мэдээг сар бүрийн 07-ны өдрийн дотор газрын шилэн данс, вэйб сайт, мэдээллийн самбарт байршуулсан. Мөн байгууллагын 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан, аудитын зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр шилэн данс, вэйб сайтад байршуулсан.	100
11	3.2.. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох;	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнан ажиглаж байна. Зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.	100
12	3.3.. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх.	“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” нь 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Монгол Улсын Засгийн газраар хэлэлцүүлэгдэж Монгол Улсын Их хуралд өргөн барихаар дэмжигдсэнтэй холбогдуулан Нийслэлийн 9-н дүүргийн иргэд олон нийтэд танилцуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.	100

	13		1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах салбарын удирдлагын манлайлыг мэргэжлийн түвшинд гаргах зорилгоор мөрит зарчмыг баримтлан олон жил ажилласан чадварлаг боловсон хүчнүүдийг дэмжин мэргэжилтэн болон инженерээс хэлтсийн дарга, ерөнхий инженер хүртэл дэвшүүлэн ажиллаж байна.	100
	14	ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА, ДЭГ ЖУРАМ, ХАРИУЦЛАГЫГ	2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зорилгоор Шил ажиллагааны нэгдсэн системд Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 3-р улирлын тайланг илгээж хянуулан баталгаажуулсан. Нийт 87 үзүүлэлтийн дагуу байгууллагад хамаарах нийтийн ил тод байдлын мэдээллүүдийг хугацаанд нь байршуулсан. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно.	100
2	15	ЧАНГАТГАХ ТУХАЙ АЛБАН ДААЛГАВАР 2025-07-08 ДУГААР 2025_03	2.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар болон Авлигын эсрэг үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас болон институтийн Facebook хуудаст тухай бүр байршуулж, албан хаагчид, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааг иргэдэд таниулах, урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 5 постер, мэдээ мэдээллийг олон нийтийн интернэт сүлжээнд болон институтийн цахим хуудаснаа байршуулсан. Байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Байгууллагын даргын дэргэд Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд ёс зүйн дэд хороонд ирсэн аливаа гомдол байхгүй болно.	100
	16		1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давахардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо	Тус институт нь НЗД-ын 2023 оны А/312 дугаар захирамж, 2025 оны А/07 дугаар захирамжийн дагуу 82 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тус институт нь байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргаагүй бөгөөд одоогийн байдлаар 62 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.	100

	ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЛЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04	17	Болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад; 1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад; 1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	Төрийн албан хаагчийн ёс, зүй, авлига, ашиг сонирхлын талаарх анхааруулга, санамж постерыг байгууллагын цахим хаягт байршуулан албан хаагч, иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна. Байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Байгууллагын даргын дэргэд Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулан ажиллаж байна.	100
					100

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

ЗАХИРГАА, МЕНЕЖМЕНТИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ОЛОН НИЙТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

ХАРИУЦСАН МЭРТЭЖИЛТЭН

Л.ЭРДЭНЭБАТ

Х.МӨНХНАРАН

Г.БУЯНХИШИГ